

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	5
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	8
3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	8
3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	9
3.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	11
3.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	13
3.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14
3.6. Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
АВТО БААЗЫН ДАРГА, ЦАГДААГИЙН
ХУРАНДАА Ж.ЭРДЭНЭБУЛГАН
ТАНАА

2020.02.21 № 06/572
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ЦЕГ-ын Авто баазын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

ЦЕГ-ын Авто баазын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар ЦЕГ-ын Авто баазын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

ЦЕГ-ын Авто баазын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Авто баазын дарга, Цагдаагийн хурандаа Ж.Эрдэнэбулган Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ЦЕГ-ын Авто баазын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

ЦЕГ-ын Авто баазын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 3-наас 2020 оны 2 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор О.Баярмаа хариуцаж хэрэгжүүлэв.

ЦЕГ-ын Авто бааз нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 6в/86 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

ЦЕГ-ын Автобааз нь цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргээ биелүүлэхэд албаны болон тусгай зориулалтын автомашинаар үйлчлэх, тэдгээрийн засвар үйлчилгээг стандартын дагуу хийж гүйцэтгэх үндсэн чиг үүрэгтэй.

Мөн нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн, жагсаал цуглааны үед албаны бэлэн байдлыг хангаж алба хаагч нар нэмэлтээр хэв журам сахиулах туслах чиг үүрэгтэйгээр ажилладаг.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

ЦЕГ-ын Автобаазын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус байгууллага нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн “Acolous” программ хангамж ашигладаг байна.

ЦЕГ-ын Автобаазын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар ЦЕГ-ын Автобаазын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 5 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 3,853,781.1 мянган төгрөгөөс тооцон 38,537.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын түвшинг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

ЦЕГ-ын Автобаазын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,939,422.0 мянган төгрөгөөр буюу 17.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгийн дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урьдчилгаа тооцоо	12,111.9	7,104.8	(5,007.1)
Бараа материал	508,724.0	399,200.6	(109,523.4)
Үндсэн хөрөнгө	10,339,660.9	12,393,613.4	2,053,952.5

Нийт хөрөнгө	10,860,496.9	12,799,918.8	1,939,422.0
Засгийн газрын хувь оролцоо	10,860,496.9	12,799,918.8	1,939,422.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	10,860,496.9	12,799,918.8	1,939,422.0

Бараа материалын дансны үлдэгдэл нийт дүнгээр буурсан боловч төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа материал 2,063,112.7 мянга, системийн дотоод тооцоогоор шилжүүлэн авсан 319,925.0 мянга, даатгалаас олгосон хохирлын нөхөн төлбөр 39,773.8 мянга, малын нас дэвшилтийн 14,279.4 мянга, нийт 2,437,090.9 мянган төгрөгийн орлого орж, 29,230.2 мянган төгрөгийн залруулгын гүйлгээ хийсэн байна.

Тайлант хугацаанд албан хэрэгцээнд зарцуулсан 2,382,729.5 мянга, системийн дотоод тооцоогоор бусад салбар нэгжүүдэд шилжүүлсэн 126,778.5 мянга, акталсан 8,145.1 мянга, малын нас дэвшилтийн 6,323.4 мянга, залруулсан 51,846.1 мянга, нийт 2,575,822.6 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл нийт дүнгээр буурсан үзүүлэлттэй байгаа нь тайлант онд системийн дотоод тооцоогоор бусад салбар нэгжүүдэд шилжүүлсэн, бараа материалаас үндсэн хөрөнгөнд шилжүүлэн залруулсан, мөн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу залруулга хийсэн зэргээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,053,952.5 мянган төгрөгөөр өссөн нь үлдэх өртөггүй цаашид ашиглах боломжтой автомашины үнийг шинэчлэн тогтоож, ашиглах хугацааг сунгасан, системийн дотоод тооцоогоор бусад салбар нэгжүүдээс автомашин шилжүүлэн авсан зэргээс шалтгаалжээ.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан тоног төхөөрөмжийн үнэ 5,286.5 мянга, Сангийн яам, ХЗДХЯ, БОАЖЯ, Бамбай сервис ХХК-аас үнэ төлбөргүй хүлээн авсан 116,386.2 мянга, системийн дотоод тооцоогоор шилжүүлэн авсан 1,782,853.1 мянга, анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн автомашины үнийг шинэчлэн тогтоосон 2,008,468.0 мянга, нийт 3,912,993.8 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Мөн холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг үндэслэн акталсан, худалдсан 115,873.4 мянга, системийн дотоод тооцоогоор бусад салбар нэгжүүдэд шилжүүлсэн 67,144.5 мянга, ХЗДХЯ-нд шилжүүлсэн 407,300.0 мянга, үлдэх өртөггүй цаашид ашиглах боломжтой автомашины үнийг шинэчлэн тогтоосон 6,038,721.9 мянга, нийт 6,629,039.8 мянган төгрөгийн хөрөнгө хасагдаж, 8,083.3 мянган төгрөгийн залруулга хийсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 12,799,918.8 мянган төгрөг болж 1,939,422.0 мянган төгрөгөөр өссөн нь үлдэх өртөггүй цаашид ашиглах боломжтой хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоосон, бусад байгууллага болон салбар нэгжүүдээс системийн дотоод тооцоогоор үндсэн хөрөнгө шилжүүлэн авсан зэргээс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 936.0 мянган төгрөгийн бичилт нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 644 тогтоолоор цаашид ашиглах боломжтой, үлдэх өртөггүй хүндэтгэлийн хөшөө, зурагтын тавиурын дахин үнэлэгдсэн зөрүү дүнгээр өмнөх үеийн үр дүнд өөрчлөлт оруулсан байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчид үндсэн чиг үүргээ биелүүлэхэд зориулж 4,837,001.4 мянган төгрөгийн төсөв баталсан байна. Нийт зардлыг улсын төсвөөс бүрэн санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,836,697.8 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь байр ашиглалттын зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Нэмэлт санхүүжилтээр байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зарим асуудлыг шийдвэрлэхэд зориулж 5,614.9 мянган төгрөгийг олгосноос, урсгал засварт 2,964.6 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалд шимтгэлд 2,650.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн гүйцэтгэх үе шатанд 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн баталгаажуулсан.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 8 горим сорил гүйцэтгэхэд алдаа, зөрчил илрээгүй болно.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргээ биелүүлэхэд зориулж, 2018 оны хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн “тоёото ландкрузер L200 VXR” маркийн 1 ширхэг, “хьюндай соната” маркийн 2 ширхэг, нийт 3 ширхэг шинэ автомашиныг 2019 оны 1 дүгээр сард ХЗДХЯ-д шилжүүлсэн байгааг дараагийн аудитаар авч үзэхээр тусгасан болно.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Төсвийн шууд захирагч нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 44 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 58,889.4 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах 1 зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид ЦЕГ-ын Автобаазын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

ЦЕГ-ын Автобаазын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	520,835,926.39	406,305,421.21
34	УРЬДЧИЛГАА	12,111,948.67	7,104,837.96
3471	Урьдчилгаа тооцоо	12,111,948.67	7,104,837.96
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	12,111,948.67	7,104,837.96
35	БАРАА МАТЕРИАЛ	508,723,977.72	399,200,583.25
351	Түүхий эд материал	16,217,672.40	87,292,655.40
35110	Тусгай зориулалттай материал	16,179,172.40	86,877,351.40
35130	Эм боох материал	38,500.00	415,304.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	22,888,100.00	-
354	Хангамжийн материал	463,113,005.32	298,491,895.85
35410	Бичиг хэргийн материал	6,050,803.15	6,555,379.15
35420	Аж ахуйн материал	44,328,459.00	19,574,555.00
35430	Сэлбэг хэрэгсэл	71,973,602.00	61,849,760.00
35440	Түлш, шатах тослох материал	95,572,408.57	19,439,804.49
35450	Барилгын засварын материал	14,076,930.00	1,861,810.00
35460	Хүнсний материал	964,800.00	-
35470	Бусад хангамжийн материал	230,146,002.60	189,210,587.21
35600	Мал амьтад	6,505,200.00	13,416,032.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	10,339,660,925.62	12,393,613,383.89
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,339,660,925.62	12,393,613,383.89
392	Биет хөрөнгө	9,428,687,345.62	11,483,538,203.89
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,920,778,079.82	4,920,778,079.82
39202	Хуримтлагдсан элэгдэл	(289,813,025.12)	(466,901,515.28)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	12,061,281,178.12	9,441,566,123.96
39204	Хуримтлагдсан элэгдэл	(7,573,800,078.33)	(2,735,011,428.77)
39205	Машин тоног төхөөрөмж	503,600,841.32	409,758,294.64
39206	Хуримтлагдсан элэгдэл	(218,354,789.21)	(116,462,761.52)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	67,034,007.69	58,386,571.52
39208	Хуримтлагдсан элэгдэл	(46,736,045.68)	(35,918,763.13)
39214	Бусад үндсэн хөрөнгө	16,605,790.00	14,156,590.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(11,908,612.99)	(6,812,987.35)
393	Биет бус хөрөнгө	910,973,580.00	910,075,180.00
39301	Программ хангамж	10,934,500.00	11,459,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,014,300.00)	(6,437,700.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	905,053,380.00	905,053,380.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	10,860,496,852.01	12,799,918,805.10
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,860,496,852.01	12,799,918,805.10
51	Засгийн газрын хувь оролцоо	10,860,496,852.01	12,799,918,805.10
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	14,093,882,286.75	14,093,882,286.75
51101	Өмч: - төрийн	14,093,882,286.75	14,093,882,286.75
512	Хуримтлагдсан үр дүн	(5,221,470,983.26)	(3,281,113,048.51)
51210	Өмнөх үеийн үр дүн	(5,221,470,983.26)	(5,220,535,001.60)
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,939,421,953.09
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,988,085,548.52	1,987,149,566.86
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,860,496,852.01	12,799,918,805.10

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	7,711,054,472.45	9,351,844,926.37
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,487,255,472.45	4,510,468,626.37
120	Нийтлэг татварын бус орлого	3,487,255,472.45	4,510,468,626.37
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	26,054,627.00	2,123,678,385.95
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,214,984.00	3,579,161.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	191,743.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,647,900.00	2,120,099,224.95
	Системийн дотоод тооцоо	3,461,200,845.45	2,386,790,240.42
	Системийн дотоод санхүүжилт /хөрөнгөөр/	2,744,278,292.26	1,782,853,157.00
	Системийн дотоод санхүүжилт /мөнгөөр/	463,056,962.19	407,914,069.91
	Системийн дотоод санхүүжилт /материалаар/	253,865,591.00	196,023,013.51
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,223,799,000.00	4,841,376,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,223,799,000.00	4,835,761,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,223,799,000.00	4,835,761,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	5,614,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	5,614,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,117,769,488.80	7,404,848,340.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,117,769,488.80	7,404,848,340.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,115,894,426.80	7,388,666,588.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,508,171,878.00	2,875,764,904.00
210101	Үндсэн цалин	1,704,865,000.00	2,267,990,176.00
210102	Нэмэгдэл	803,306,878.00	607,774,728.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,683,960.00	81,390,749.27
210201	Тэтгэврийн даатгал	19,760,734.00	20,007,496.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,450,441.00	2,396,553.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,938,153.00	1,640,164.00
210204	Ажилгүйдлийн даатгал	421,147.00	652,964.00
210205	Эрүүл мэндийн даатгал	49,113,485.00	56,693,572.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	92,724,800.00	140,130,358.99
210301	Гэрэл, цахилгаан	33,673,065.00	47,688,486.23
210302	Түлш, халаалт	50,626,273.00	84,388,735.25
210303	Цэвэр, бохир ус	8,425,462.00	8,053,137.51
2104	Хангамж, бараа материалын зардал	1,615,200,059.89	1,762,435,880.35
210401	Бичиг хэрэг	5,128,355.00	7,056,844.00
210402	Тээвэр, шатахуун	1,544,129,052.89	1,717,843,132.35
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,890,000.00	2,800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,434,479.00	8,577,127.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	52,624,377.00	18,013,680.00
210408	Бараа материал акталсны зардал	5,993,796.00	8,145,097.00

ЦЕГ-ын Авто баазын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2105	Нормативт зардал	8,604,474.00	24,100,656.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	48,196.00
210502	Хоол, хүнс	8,299,740.00	5,820,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	304,734.00	18,232,460.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	485,576,547.00	580,107,744.25
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	31,562,737.00	9,243,252.25
210604	Урсгал засвар	454,013,810.00	570,864,492.00
2107	Томилолт, зочны зардал	21,679,500.00	30,744,500.00
210702	Дотоод албан томилолт	21,679,500.00	30,744,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,692,631.00	45,566,197.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	24,864,439.00	33,376,691.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	6,368,504.00	6,379,506.00
210807	Газрын төлбөр	2,459,688.00	5,810,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,276,560,576.91	1,848,425,598.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,487,400.00	413,623,352.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,480,865.00	1,400,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,265,592,311.91	1,433,402,246.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,875,062.00	16,181,751.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	13,867,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	13,867,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,875,062.00	2,313,951.74
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,875,062.00	2,313,951.74
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	1,593,284,983.65	1,946,996,585.89
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	49,177,584.49	4,052,655.64
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	49,177,584.49	4,052,655.64
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	269,404,186.77	11,627,288.44
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	267,229,109.77	11,627,288.44
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	2,175,077.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(220,226,602.28)	(7,574,632.80)
5	НИЙТ ҮР ДҮН	1,373,058,381.37	1,939,421,953.09

3.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	4,239,013,984.00	4,844,626,682.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,214,984.00	3,250,382.00
120	Нийтлэг татварын бус орлого	15,214,984.00	3,250,382.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,214,984.00	3,250,382.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,214,984.00	3,250,382.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,223,799,000.00	4,841,376,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,223,799,000.00	4,835,761,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,223,799,000.00	4,835,761,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	5,614,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	5,614,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,238,034,984.00	4,839,340,182.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,238,034,984.00	4,839,340,182.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,236,159,922.00	4,824,146,230.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,508,171,878.00	2,875,419,224.00
210101	Үндсэн цалин	1,704,865,000.00	1,895,783,224.00
210102	Нэмэгдэл	803,306,878.00	979,636,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,492,217.00	81,390,750.27
210201	Тэтгэврийн даатгал	19,760,734.00	1,719,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,450,441.00	202,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,746,410.00	161,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	421,147.00	40,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	49,113,485.00	79,266,850.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	92,724,800.00	140,130,358.99
210301	Гэрэл, цахилгаан	33,673,065.00	47,688,486.23
210302	Түлш, халаалт	50,626,273.00	84,388,735.25
210303	Цэвэр, бохир ус	8,425,462.00	8,053,137.51
2104	Хангамж, бараа материалын зардал	1,081,662,000.00	1,156,662,000.00
210401	Бичиг хэрэг	4,097,050.00	3,096,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,068,766,000.00	1,148,766,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,890,000.00	2,800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,908,950.00	2,000,000.00
2105	Нормативт зардал	17,751,000.00	10,720,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	400,000.00
210502	Хоол, хүнс	4,445,940.00	5,820,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,305,060.00	4,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	410,527,200.00	482,113,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	214,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,832,640.00	8,500,000.00
210604	Урсгал засвар	403,694,560.00	473,398,700.00
2107	Томилолт, зочны зардал	18,000,000.00	30,744,500.00
210702	Дотоод албан томилолт	18,000,000.00	30,744,500.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,431,027.00	45,566,197.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	24,864,439.00	33,376,691.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	3,106,900.00	6,379,506.00
210807	Газрын төлбөр	2,459,688.00	5,810,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,399,800.00	1,400,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,399,800.00	1,400,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,875,062.00	15,193,951.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	12,880,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	12,880,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,875,062.00	2,313,951.74
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,875,062.00	2,313,951.74
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	979,000.00	5,286,500.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	979,000.00	5,286,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	979,000.00	5,286,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	979,000.00	5,286,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	979,000.00	5,286,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(979,000.00)	(5,286,500.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,188,828,906.75	24,394,976.16	(6,594,529,364.63)	6,618,694,518.28
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,188,828,906.75	24,394,976.16	(6,594,529,364.63)	6,618,694,518.28
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	1,963,690,572.36	-	1,963,690,572.36
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Тайлант үеийн үр дүн	905,053,380.00	-	1,373,058,381.37	2,278,111,761.37
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,093,882,286.75	1,988,085,548.52	(5,221,470,983.26)	10,860,496,852.01
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	935,981.67	935,981.67
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	14,093,882,286.75	1,988,085,548.52	(5,220,535,001.59)	10,861,432,833.68
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(935,981.67)	-	(935,981.67)
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн	-	-	1,939,421,953.09	1,939,421,953.09
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,093,882,286.75	1,987,149,566.85	(3,281,113,048.50)	12,799,918,805.10

3.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл				
I.НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,837,001,400.00	4,836,697,830.26	303,569.74	100.0
II.НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	4,837,001,400.00	4,836,697,830.26	303,569.74	100.0
III. УРСГАЛ ЗАРДАЛ	4,837,001,400.00	4,836,697,830.26	303,569.74	100.0
Бараа, ажил үйлчилгээний зардал	2,954,192,000.00	2,954,159,974.27	32,025.73	100.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,875,444,700.00	2,875,419,224.00	25,476.00	100.0
Үндсэн цалин	1,895,808,700.00	1,895,783,224.00	25,476.00	100.0
Нэмэгдэл	979,636,000.00	979,636,000.00	-	100.0
Нийгмийн даатгалын шимтгэл	78,747,300.00	78,740,750.27	6,549.73	100.0
Тэтгэврийн даатгал	1,719,300.00	1,719,300.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	202,300.00	202,300.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	161,800.00	161,800.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	40,500.00	40,500.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	76,623,400.00	76,616,850.27	6,549.73	100.0
Бараа үйлчилгээний урсгал зардал	1,882,809,400.00	1,882,537,855.99	271,544.01	100.0
Гэрэл, цахилгааны зардал	47,701,500.00	47,688,486.23	13,013.77	100.0
Түлш, халаалтын зардал	84,397,900.00	84,388,735.25	9,164.75	100.0
Цэвэр, бохир усны зардал	8,283,000.00	8,053,137.51	229,862.49	97.2
Хоол	5,820,000.00	5,820,000.00	-	100.0
Эм	400,000.00	400,000.00	-	100.0
Бичиг хэргийн материал	3,096,000.00	3,096,000.00	-	100.0
Тээвэр, шатахууны зардал	1,148,766,000.00	1,148,766,000.00	-	100.0
Шуудан, холбооны зардал	2,800,000.00	2,800,000.00	-	100.0
Дотоод томилолтын зардал	30,762,000.00	30,744,500.00	17,500.00	99.9
Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардал	1,400,000.00	1,400,000.00	-	100.0
Жижиг эд хогшил худалдан авах зардал	7,501,000.00	7,501,000.00	-	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	13,000,000.00	13,000,000.00	-	100.0
Төлбөр хураамж, жижиг татварууд	45,568,200.00	45,566,197.00	2,003.00	100.0
Урсгал засварын зардал	470,433,800.00	470,433,800.00	-	100.0
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	12,880,000.00	12,880,000.00	-	100.0
VI. ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,837,001,400.00	4,836,697,830.26	303,569.74	100.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,240,000.00	3,250,382.00	(2,010,382.00)	262.1
Төсвөөс санхүүжих	4,835,761,400.00	4,833,447,448.26	2,313,951.74	99.9
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт	-	-	-	-
Байгууллагын тоо	1	1	-	100.0
Ажиллагсад бүгд	252	252	-	100.0
Удирдах ажилтан	2	2	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	216	216	-	100.0
Үйлчлэх ажилтан	34	34	-	100.0

3.6. Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
А	Б	В
Мөнгөн хөрөнгийн 2020 оны 1-р сарын 1-ны үлдэгдэл		-
ОРЛОГЫН ДҮН		5,614,900.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		5,614,900.00
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН		5,614,900.00
А.УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН		5,614,900.00
1. Бараа үйлчилгээний зардал		2,650,000.00
1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		2,650,000.00
Эрүүл мэндийн даатгал		2,650,000.00
1.3 Бараа үйлчилгээний бусад зардал		2,964,900.00
Урсгал засвар		2,964,900.00
Мөнгөн хөрөнгийн 2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл		-